



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/28 дугаар тушаал, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа ч хийгдэж дуусаагүй, он дамжсан 4 төсөл арга хэмжээ байна.

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/24

Улаангом

Аудитын тайлан батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар 6.3.1, 6.3.3 дахь заалт, 9 дүгээр зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /УВА-2021/113-ШТА-ГА/ хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох бусад газруудад тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер М.Бат-Амгалан, ахлах аудитор С.Батсайхан нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ



0200100065

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл.....	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	5
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.	6
Барилга, байгууламжийн зураг, төсвийг захиалагч болон хэрэглэгчийн шаардлагад нийцүүлсэн ажлын даалгавраар зохиосон байна.	6
Барилга байгууламжийн зураг, төсвийг захиалагчийн тавьсан шаардлагын дагуу боловсруулсан байна.	7
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сан, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр нийт 34 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аар баталжээ.....	7
Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулсан байна.	8
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.....	9
Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.	9
Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд томилогдсон гишүүдийн 14.5-28.5 хувь нь худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх гэсэн шаардлагыг хангаагүй байна.	10
Захиалагч болон гүйцэтгэгчээс шалтгаалан 4 төсөл, арга хэмжээ гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй байна.....	11
Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлагыг хангаж байна.	15
Хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон гэр хорооллын дэд бүтцийн шугамыг тухайн ашиглагч байгууллагын хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.	15
Гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.....	16
Захиалагч болон зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр арилгуулж ажилласан байна.....	17
ДҮГНЭЛТ:	18
Холбогдох байгууллагын санал.....	19
Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар.....	22
ЗӨВЛӨМЖ:	13

Товчилсон үгийн тайлбар

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УДДТ	Ус дулаан дамжуулах төв
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар

Хавсралтууд

Дугаар	Хавсралтын нэр	Хуудасны дугаар
1	Шинээр төлөвлөж буй ажлын зураг төсвийн жагсаалт	24
2	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын гүйцэтгэлийн зураг /багц -1/	25
3	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын гүйцэтгэлийн зураг /багц -2/	25
4	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын гүйцэтгэлийн зураг /багц -3/	26
5	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын гүйцэтгэлийн зураг /багц -4/	26
6	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын гүйцэтгэлийн зураг /багц -5/	27
7	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын гүйцэтгэлийн зураг /багц -6/	27
8	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын гүйцэтгэлийн зураг /багц -7/	27
9	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын гүйцэтгэлийн зураг /багц -8/	27
10	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын гүйцэтгэлийн зураг /багц -9/	28
11	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын гүйцэтгэлийн зураг /багц -10/	28
12	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын гүйцэтгэлийн зураг /багц -11/	28
13	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын гүйцэтгэлийн зураг /багц -12/	29

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Дугаар	Нэр	Хуудасны дугаар
1	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт /мянган төгрөг/	5-6
2	Аймгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт /мянган төгрөг/	6
3	Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт /мянган төгрөг/	6
4	Төсөл, арга хэмжээний санхүүжилт, ажлын гүйцэтгэл /мянган төгрөг/	
5	ТАХ-ний хүрээнд нийлүүлэгдсэн машин, тоног төхөөрөмж /мянган төгрөг/	

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” А/28 дугаар тушаалыг үндэслэн Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт үр нөлөөтэй байгаа эсэх,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Авто замын сан, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэхээр баталсан 34 төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага болон төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчийн холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг арга зүйг ашиглав.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Дараах хууль, эрх зүйн актыг аудитын гол шалгуур үзүүлэлтээр эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;

-
- Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
 - Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт;
 - Барилгын норм ба дүрэм, бусад эрх зүйн актууд;

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар болон Замын сан, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тусгах сумдын саналыг албан тоотоор, мөн аймгийн ИТХ-ын төлөөлөгчид болон төсөвт байгууллагын удирдлагуудын саналыг авч нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал болон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн Увс аймгийн Хөгжлийн стратеги төлөвлөгөө /2008-2021/, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Увс аймгийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэл, нийгэм эдийн засгийн зорилт, салбарын бодлоготой уялдуулан, ач холбогдлоор нь эрэмбэлж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 11/02 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 23 төсөл, арга хэмжээг 10326.6 сая, аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 9 төсөл, арга хэмжээг 381.1 сая, Авто замын сангийн хөрөнгөөр 2 төсөл, арга хэмжээг 360.0 сая, нийт 11067.1 сая төгрөгийн 34 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аудит хийх явцад аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/250, 2021 оны 5, сарын 28-ны өдрийн А/293 дугаар захирамж, Улаангом сумын засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/162 дугаар захирамжаар аймаг, сумдад ковид-19 цар тахал тархсаны улмаас хөл хорио тогтоож, орох гарах хөдөлгөөнийг хязгаарласан тул сумдад орон нутгийн хөрөнгө оруулалт, байгаль хамгаалах сан, авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг нүдээр үзэж, ажлын зураг авалт хийж зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай харьцуулж шалгах боломжгүй байсан.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

1.1. Шинээр баригдах барилга, байгууламжийн зураг төсөвт магадлал хийсэн байна.

1.1.1. Барилга, байгууламжийн зураг, төсвийг захиалагч болон хэрэглэгчийн шаардлагад нийцүүлсэн ажлын даалгавраар зохиосон байна.

Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх хэсэгт “Эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх” гэж заажээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хийгдэх Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугам, Улаангом сумын гэр хороололд бохирын шугамын ажил, Давст сумын халуун усны барилга, Улаангом сум доторх авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, зогсоол, засвар арчлалт, Улаангом-Улаан уул чиглэлд дугуйн зам, явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг хийх, авто замыг сайжруулах ажлуудын зураг төсөл зохиох ажлын даалгаврыг салбарын бодлого, хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлага, геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэрэгт үндэслэн боловсруулсан байна.

Барилга, байгууламжийн төсөвт өртгийг зохиохдоо Засгийн газрын 2010 оны 336 дугаар “Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай” тогтоолыг мөрдөж ажилласан байна.

Ингэхдээ аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүд оролцуулсан ажлын хэсэг 2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр “Барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх, засварлах, тоноглох, буулгалтын ажлын зураг төсвийг магадлалаар оруулах” талаар хуралдаж дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

- Барилга байгууламжийн үндсэн хийц бүтцэд өөрчлөлт орсон засварын ажлын зураг төсвийг магадлалд оруулна.
- Барилга байгууламжийн үндсэн хийц бүтцэд өөрчлөлт ороогүй бол засварын ажлын зураг төсөвт магадлал хийлгэхгүй.
- Зураг төсвийн байгууллага магадлалыг хариуцан хийлгэнэ.
- Энэ асуудлыг зураг төсөв боловсруулах гэрээнд заалт болгож оруулахыг захиалагчид даалгах.

Дээрх шийдвэрийн дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугам, Улаангом-Улаан уул чиглэлд дугуйн зам, явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг хийх, авто замыг сайжруулах ажлуудад Барилга хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвөөс магадлал хийж ерөнхий дүгнэлт гаргасан байна.

1.1.2. Барилга байгууламжийн зураг, төсвийг захиалагчийн тавьсан шаардлагын дагуу боловсруулсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд 8 барилга, байгууламж, 9 засвар тохижилт, машин тоног төхөөрөмж худалдан авах 6 ажил, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх 8, Авто замын сангийн хөрөнгөөр 2 ажил хийхээр төлөвлөсөн байна.

Дээрх төлөвлөсөн 8 барилга, байгууламж болон авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх 2 ажлыг зураг төсвийг Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтад “Барилгын зураг төсөл дараах шаардлагыг хангасан байна”, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Зураг төсөл зохиогч дараах чиг үүрэгтэй”, 38.1.1 дэх заалтад “Барилга байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцүүлэн хөрөнгө оруулалтын үр ашиг болон техникийн тооцоонд тулгуурлан боловсруулах” гэж заасны дагуу захиалагчийн тавьсан шаардлагын дагуу боловсруулсан байна.

Түүнчлэн барилга байгууламжийн үндсэн хийц бүтцэд өөрчлөлт ороогүй төсөвт өртөг багатай Зүүнхангай сумын Баянгол багийн төвийн засвар, Өндөрхангай сумын баруун голын модон гүүр барих, цэвэр усны 2-р эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах хашаа, хамгаалалт, Улаангом сумын ногоон байгууламж, Улаангом сумын 3-р багийн орон сууцны тохижилт, Улаангом сумын 2-р багт тоглоомын талбай барих, Наранбулаг сумын хөдөөгийн багийн төвүүдийг засварлах, тохижуулах гэсэн төсөл, арга хэмжээнүүдийн хүрээнд хийгдэх ажлын даалгаврыг боловсруулжээ.

1.2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 34 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

1.2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сан, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр нийт 34 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аар баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 11/02 тоот тогтоолоор 2020 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10326.6 сая төгрөгөөр 23 төсөл, арга хэмжээ, Замын сангийн хөрөнгөөр 360.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 381.1 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн баталсан байна. Үүнд:

Хүснэгт № 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих ТАХ /мянган төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
1.1	4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажил	2020-2020	9,000,000.0	8,908,000.0
1.2	Улаангом сумын гэр хороололд бохирын шугамын ажил	2020-2020	50,000.0	50,000.0
1.3	Улаангом сумын гэр хороололд дэд бүтцийн шугамын нэмэлт ажил	2020-2020	42,675.4	42,675.4
1.4	50 ортой хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж	2020-2020	300,000.0	100,000.0
1.5	Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэлтийн тасгийн тоног төхөөрөмж	2020-2020	50,000.0	50,000.0
1.6	Зүүнхангай сумын Баянгол багийн төвийн байрны засвар	2020-2020	15,000.0	15,000.0

1.7	Зүүнговь сумын сургуулийн сургалтын тоног төхөөрөмж	2020-2020	4,000.0	4,000.0
1.8	Давст сумын халуун усны барилга	2020-2020	45,000.0	45,000.0
1.9	Аймгийн аудитын газарт автомашин	2020-2020	20,000.0	20,000.0
1.10	Хилийн зарим заставуудад нарны самбар, хөлдөөгч нийлүүлэх	2020-2020	25,000.0	25,000.0
1.11	Цагдаагийн газарт камерын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж	2020-2020	25,000.0	25,000.0
1.12	Улаангом сумын цэвэр усны эх үүсвэрийн шугамын засвар	2020-2020	68,000.0	68,000.0
1.13	Цэвэр усны 2-р эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах хашаа, хамгаалалт	2020-2020	40,000.0	40,000.0
1.14	Улаангом сумын ногоон байгууламжийн ажлын дутуу санхүүжилт	2014-2020	14,900.0	14,900.0
1.15	Шинээр төлөвлөж буй ажлын зураг төсөв хийлгэх	2020-2020	550,000.0	550,000.0
1.16	Завхан суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулах	2020-2020	80,000.0	80,000.0
1.17	Завхан сумын төвийн тохижилт	2020-2020	80,000.0	80,000.0
1.18	Өндөрхангай сумын баруун голын модон гүүр барих	2020-2020	40,000.0	40,000.0
1.19	Улаангом сумын 3-р багийн орон сууцны тохижилт	2020-2020	50,000.0	50,000.0
1.20	Улаангом сумын 2-р багт тоглоомын талбай барих	2020-2020	50,000.0	50,000.0
1.21	Наранбулаг сумын хөдөөгийн багийн төвүүдийг засварлах, тохижуулах	2020-2020	25,000.0	25,000.0
1.22	Тариалан сумын төвийн тохижилт	2020-2020	40,000.0	40,000.0
1.23	Улаангом сумын 8-р багт голын гольдрол өөрчлөн суваг татах	2020-2020	4000.0	4000.0
Бүгд дүн			10,618,575.4	10,326,575.4

/Эх сурвалж: Увс аймгийн ИТХ-ын тогтоол/

Хүснэгт № 2. Аймгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжих ТАХ /мянган төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
1.1	Улаангом сум доторх авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, зогсоол, засвар арчлалт	2020-2020	110,000	110,000
1.2	Улаангом - Улаан уул чиглэлд дугуйн зам, явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг хийх, авто замыг сайжруулах ажил	2019-2020	492,500	250,000

/Эх сурвалж: Увс аймгийн ИТХ-ын тогтоол/

Хүснэгт № 3. Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжих ТАХ /мянган төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
1.1	Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадсыг нэмэгдүүлэх	2020-2020	20,000.0	20,000.0
1.2	Зэрлэг ан амьтдад биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх	2020-2020	30,000.0	30,000.0
1.3	Улаангом сумын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх	2020-2020	110,000.0	110,000.0
1.4	Улаангом сумын ногоон байгууламж нэмэгдүүлэх	2020-2020	75,000.0	75,000.0
1.5	Байгаль орчны салбарын мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах, чадавхжуулах үйл ажиллагааны зардал	2020-2020	11,100.0	11,100.0
1.6	Байгаль орчны эсрэг үйл ажиллагааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал	2020-2020	20,000.0	20,000.0
1.7	Цэвэр усны эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний зардал	2020-2020	30,000.0	30,000.0
1.8	Мэргэжлийн хяналтын газарт автомашины дэмжлэг	2020-2020	15,000.0	15,000.0
1.9	18 сум, Улаангом хотын ундны усанд чанарын шинжилгээ хийж мэдээллийн сан үүсгэн технологийн шийдэл сонгох төсөл	2020-2020	70,000.0	70,000.0
Бүгд дүн			381,100.0	381,100.0

/Эх сурвалж: Увс аймгийн ИТХ-ын тогтоол/

1.2.2. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 22 төсөл, арга хэмжээг 2020 онд, 1 төсөл, арга хэмжээг 2014-2020 онд, аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжих 9 төсөл, арга хэмжээг 2020 онд, Замын сангийн хөрөнгөөр санхүүжих 1 төсөл, арга хэмжээг 2020 онд, 1 төсөл, арга хэмжээг 2019-2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж санхүүжилтийг баталсан нь хугацаандаа хэрэгжих боломжтой байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

2.1. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулжээ.

2.1.1. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 23, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдэх 9, Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх 2 нийт 34 төсөл, арга хэмжээнээс 8 төсөл, арга хэмжээнд Орон нутгийн өмчийн газар худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Ингэхдээ Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугам, 50 ортой хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх, Улаангом-Улаан уул чиглэлд дугуйн зам, явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг хийх, авто замыг сайжруулах, Улаангом сум доторх авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, зогсоол, засвар арчлалт гэсэн 4 төсөл, арга хэмжээг нээлттэй, Давст сумын халуун усны барилга, Улаангом сумын 3 багийн тохижилт, Улаангом сумын 2-р багт тоглоомын талбай барих, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын авто машин худалдан авах гэсэн 4 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргыг тус тус ашиглан цахимаар зохион байгуулсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн захирамжаар төсөл, арга хэмжээ бүрд үнэлгээний хороог томилсон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно”, 34.1.1 дэх заалтад “Энэ хуулийн 30.4.3, 36.18-д заасан тохиолдолд” гэж заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 2 удаа тендер зарлаад амжилтгүй болсон Улаангом сум доторх авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, зогсоол, засвар арчлалтын ажилд шууд гэрээ байгуулсан байна.

Түүнчлэн Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5.И-д “цэвэр ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн байршлын зураг”, Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан “Барилга, хот байгуулалтын салбарын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтын 10-д заасны дагуу 18 сум, Улаангом сумын ундны усанд чанарын шинжилгээ хийж мэдээллийн сан үүсгэн технологийн шийдэл сонгох төсөл болон Улаангом сумын ундны цэвэр усны эх үүсвэрийн шугамын ажил, Улаангом сумын гэр хороололд дэд бүтцийн шугамын нэмэлт ажил, Улаангом сумын гэр хороололд бохирын шугамын ажлуудыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар дараах 21 төсөл, арга хэмжээг холбогдох байгууллага болон сумдад эрх шилжүүлсэн байна. Үүнд:

- Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэлтийн тасгийн тоног төхөөрөмж
- Зүүнхангай сумын Баянгол багийн төвийн байрны засвар
- Зүүнговь сумын сургуулийн сургалтын тоног төхөөрөмж
- Аймгийн аудитын газарт автомашин
- Хилийн зарим заставуудад нарны самбар, хөлдөөгч нийлүүлэх
- Цагдаагийн газарт камерын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж
- Цэвэр усны 2-р эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах хашаа, хамгаалалт
- Улаангом сумын ногоон байгууламжийн ажлын дутуу санхүүжилт
- Завхан суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулах
- Завхан сумын төвийн тохижилт
- Өндөрхангай сумын баруун голын модон гүүр барих
- Наранбулаг сумын хөдөөгийн багийн төвүүдийг засварлах, тохижуулах
- Тариалан сумын төвийн тохижилт
- Улаангом сумын 8-р багт голын голдирол өөрчлөн суваг татах
- Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадсыг нэмэгдүүлэх
- Зэрлэг ан амьтдад биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх
- Улаангом сумын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх
- Улаангом сумын ногоон байгууламж нэмэгдүүлэх
- Байгаль орчны салбарын мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах, чадавхжуулах үйл ажиллагааны зардал
- Байгаль орчны эсрэг үйл ажиллагааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал
- Цэвэр усны эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний зардал

Дээрх эрх шилжсэн төсөл, арга хэмжээнүүдээс Улаангом сумын 8-р багт голын голдирол өөрчлөн суваг татах ажил хийгдээгүй байна.

Мөн Завхан суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулах, Завхан сумын төвийн тохижилтын ажлын зураг төсөв батлагдаж ирэхгүй хугацаа алдсанаас он дамжуулан хэрэгжүүлэхээр гэрээ байгуулжээ.

2.1.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд томилогдсон гишүүдийн 14.5-28.5 хувь нь худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх гэсэн шаардлагыг хангаагүй байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар сумдад болон төсөвт байгууллагуудад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хороог байгуулан ажилласан байна.

Үнэлгээний хороонд аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, тухайн салбарын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан байна.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангасан хэдий ч үнэлгээний хороонд томилогдсон гишүүдийн 1-2 буюу 14.5-28.5 хувь нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна” гэсэн шаардлагыг хангаагүй байна.

Цаашид үнэлгээний хорооны гишүүдийг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн хүмүүсээр бүрдүүлж байхыг зөвлөмж болгов.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ”, 19.2 дахь хэсэгт “Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана” гэж заасны дагуу тендерийн бичиг баримтыг боловсруулжээ.

2.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулаагүй байна.

2.2.1. Захиалагч болон гүйцэтгэгчээс шалтгаалан 4 төсөл, арга хэмжээ гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сан, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр нийт 34 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аар батлагдсанаас Улаангом сумын 8-р багт голын голдирол өөрчлөн суваг татах ажил хийгдээгүй байна.

2020 онд ашиглалтад орохоор гэрээ байгуулсан дараах төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн ажил дуусаагүй байна. Үүнд:

- Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -7, багц -8/
- Улаангом сумын гэр хороололд дэд бүтцийн шугамын нэмэлт ажил
- Давст сумын халуун усны барилга
- Улаангом сум доторх авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, зогсоол, засвар арчлалт



Давст сумын халуун усны барилга



Улаангом сумын доторх авто замын тэмдэг, тэмдэглэгээ засвар арчлалт

Түүнчлэн он дамжин хэрэгжүүлэхээр гэрээ байгуулагдсан 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- 50 ортой хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажил
- Завхан суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулах
- Завхан сумын төвийн тохижилт



Завхан сумын тохижилт



Завхан сумын цэцэрлэгт хүрээлэн

Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын 9000.0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг 12 багц болгон хувааж гүйцэтгүүлсэн бөгөөд ажлын гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт № 4 Төсөл, арга хэмжээний санхүүжилт, ажлын гүйцэтгэл /мянган төгрөг/

№	Барилга байгууламжийн нэр, хүчин чадал, байршил	Гэрээний дүн	Ажил гүйцэтгэх хугацаа		Дуусаагүй шалтгаан, тайлбар
			Эхлэх	Дуусах	
1	Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -1/	485979.9	2020.08.03	2020.09.15	Ажлын гүйцэтгэл -100% Улсын комисс хүлээн авсан
2	Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -2/	698771.7	2020.08.03	2020.09.15	Ажлын гүйцэтгэл -100% Улсын комисс хүлээн авсан
3	Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -3/	547970.6	2020.08.03	2020.09.15	Ажлын гүйцэтгэл -100% Улсын комисс хүлээн авсан
4	Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -4/	1236529.5	2020.08.03	2020.09.15	Ажлын гүйцэтгэл -100% Улсын комисс хүлээн авсан
5	Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -5/	898991.2	2020.08.03	2020.09.15	Ажлын гүйцэтгэл -100% Улсын комисс хүлээн авсан
6	Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -6/	498978.1	2020.08.03	2020.09.15	Ажлын гүйцэтгэл -100% Улсын комисс хүлээн авсан
7	Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -7/	1042037.7	2020.08.03	2020.09.15	Сувгийн цутгалд стандартад хүрээгүйгээс улсын комисс хүлээн аваагүй
8	Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -8/	1198430.9	2020.08.03	2020.09.15	Барилга угсралтын ажил дуусаагүй.
9	Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -9/	868172.8	2020.08.03	2020.09.15	Ажлын гүйцэтгэл -100% Улсын комисс хүлээн авсан.
10	Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -10/	491965.9	2020.08.03	2020.09.15	Ажлын гүйцэтгэл -100% Улсын комисс хүлээн авсан
11	Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -11/	486197.9	2020.08.03	2020.09.15	Ажлын гүйцэтгэл -100% Улсын комисс хүлээн авсан
12	Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил /багц -12/	453990.6	2020.08.03	2020.09.15	Ажлын гүйцэтгэл -100% Улсын комисс хүлээн авсан.
	Нийт дүн	8908016.9			

/Эх сурвалж: Увс аймгийн ГХБХБГ/

Хүснэгтэд тусгагдсан 12 багцаас 1, 2, 3, 4, 5, 6, 9, 10, 11, 12 дугаар багцын ажлууд дуусаж, санхүүжилтийг бүрэн олгосон байна. Харин 7 дугаар багцын ажил сувгийн суурь бетон цутгалт стандартад хүрээгүйгээс улсын комисс хүлээн аваагүй, санхүүжилтийн 81.7 хувийг олгосон, 8 дугаар багцын ажлын барилга угсралтын ажил дуусаагүй бөгөөд ажлын 78.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мөн Улаангом сумын 4, 5, 11-р багт 42.7 сая төгрөгийн өртөгтэй нэмэлт ажлыг тухайн багуудад ажил гүйцэтгэхээр тендерт шалгарсан гүйцэтгэгч аж ахуй нэгжтэй нэмэлт гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн ч хүлээн аваагүй, санхүүжилтийг олгоогүй байна. Харин 4, 5, 7-р багт хийгдэх 50.0 сая төгрөгийн өртөгтэй бохирын нэмэлт ажлыг гэрээний хугацаанд хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн бөгөөд санхүүжилтийг бүрэн олгожээ.

Улаангом сум доторх авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, зогсоол, засвар арчлалтын 110.0 сая төсөвт өртөгтэй ажлын тендерт оролцогч материал ирүүлээгүй, 2 удаа тендер зарлаж хугацаа алдсанаас бүрэн хэрэгжиж дуусаагүй бөгөөд ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.

Давст сумын халуун усны барилга барих ажлын газрын маргаан үүссэний улмаас гэрээний хугацаанд баригдаж дуусаагүй байна.

Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниар хийж гүйцэтгүүлэхийг зөвлөмж болголоо.

Орон нутгийн хөрөнгө оруулалт болон Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дараах төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгчээ. Тухайлбал:

- Улаангом сумын гэр хороололд бохирын шугамын ажил
- Зүүнхангай сумын Баянгол багийн төвийн байрны засвар
- Улаангом сумын цэвэр усны эх үүсвэрийн шугамын ажил
- Цэвэр усны 2-р эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах, хашаа, хамгаалалт
- Улаангом сумын ногоон байгууламжийн ажлын дутуу санхүүжилт
- Шинээр төлөвлөж буй ажлын зураг төсөв хийлгэх
- Өндөрхангай сумын баруун голын модон гүүр барих
- Улаангом сумын 3-р багийн орон сууцны тохижилт
- Улаангом сумын 2-р багт тоглоомын талбай барих
- Наранбулаг сумын хөдөөгийн багийн төвүүдийг засварлах, тохижуулах
- Тариалан сумын төвийн тохижилт
- Улаангом - Улаан уул чиглэлд дугуйн зам, явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг хийх, авто замыг сайжруулах ажил
- 50 ортой хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж
- Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэлтийн тасгийн тоног төхөөрөмж
- Зүүнговь сумын сургуулийн сургалтын тоног төхөөрөмж
- Аймгийн аудитын газарт автомашин
- Хилийн зарим заставуудад нарны самбар, хөлдөөгч нийлүүлэх
- Цагдаагийн газарт камерын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж

Улаангом-Улаан уул чиглэлд дугуйн зам, явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг хийх, авто замыг сайжруулах ажлыг 2019-2020 оны хооронд 492.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөж, зураг төсөв хийлгэсэн боловч төсвийн нөөц боломжоос хамаарч ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулж 249.8 сая төгрөгөөр гэрээнд тусгагдсан сайжруулсан зам, явган хүний зам, хурд сааруулагчийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлын зураг төсөв хийлгэх төсөл, арга хэмжээний хүрээнд 41 ажлын зураг төсвийг 505.2 сая төгрөгөөр хийлгэсэн бөгөөд 2020 оны улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн

ажлуудад 26 зургийн ашигласан байна. Дээрх ашигласан мөнгийг тухайн ажлын санхүүжилтээс суутган аймгийн зураг төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.

Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 9 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас 7 төсөл, арга хэмжээг эрх шилжүүлж, 18 сум, Улаангом хотын ундны усанд чанарын шинжилгээ хийж мэдээллийн сан үүсгэн технологийн шийдэл сонгох төсөл нь төрийн нууцад хамаардаг тул Хот суурины Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй шууд гэрээ байгуулан 70.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна. Уг төслийн хүрээнд Увс аймгийн хэмжээнд төв, суурин газрын ундны усны 76 эх үүсвэрүүдэд усны чанарын судалгааг хийлгэж, тайлан дүгнэлтийг хүлээн авсан байна. Мөн аймгийн Мэргэжлийн хяналтын газарт prius-30 маркийн авто машин нийлүүлэгдсэнийг хүлээн авсан байна.

Түүнчлэн эрх шилжсэн 7 төсөл, арга хэмжээний хүрээнд 133.9 сая төгрөгийн хөрөнгө бий болж, 135.1 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна. Тухайлбал:

- Үүлэнд нөлөөлөх сум худалдан авах болон тээвэр шатахуун, томилолтын зардалд /аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв -20.0 сая/,
- 11 сумын нэр заагдсан газарт зэрлэг ан амьтад зориулж өвс, хужир шүү тавих, тээвэр шатахуунд /11 сум -11.0 сая, Байгаль орчин, аялал жуулчлалын газар- 1.0 сая/,
- Хогийн нэгдсэн цэгт байрлах граж, хашаа худалдан авахад /Улаангом сум -110.0 сая/,
- Төв зам дагуух цэцэг, зүлэгжүүлэлт, хятад мотоцикл худалдан авахад /Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ -75.0 сая/,
- Байгаль орчны салбарын мэргэжилтнүүдийг сургаж, дадлагажуулах, чадавхжуулах үйл ажиллагааны зардал /Байгаль орчин, аялал жуулчлалын газар -11.1 сая/,
- Байгаль орчныг хамгаалах гарын авлага, ном хэвлүүлэх, байгаль орчны эсрэг гэмт хэргийг бууруулахад зориулсан тоног төхөөрөмж авахад /аймгийн ЗДТГ -9.9 сая, цагдаагийн газарт -3.5 сая/,
- Улаангом сумын цэвэр усны эх үүсвэрийг камержуулах болон Зүүнхангай сумын ундны усны эх үүсвэрийн бохирдлыг бууруулахад /Чандмань-Увс -18.0 сая, Зүүнхангай сумын ЗДТГ-9.5 сая/

Дээрх байгаль орчны салбарын мэргэжилтнүүдийг сургаж, дадлагажуулах, чадавхжуулах үйл ажиллагааны зардлаас 6.5 сая төгрөгийн тэтгэмж олгосныг төлүүлэх актыг аймгийн байгаль хамгаалах сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон. Уг акт нь хууль хяналтын байгууллагад хянагдаж байна.

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолын 1.2 дахь хэсэгт “Монгол Улсад короновируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тохиолдол бүртгэгдэж бүх нийтийн бэлэн байдал болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс шалтгаалан эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа 2020 онд хэрэгжиж дуусах боловч батлагдсан санхүүжилтийг бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн, мөн бусад салбарын зайлшгүй шаардлагатай болон Засгийн газрын 2019 оны 280 дугаар тогтоолын хүрээнд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний 2020 оны үлдэгдэл санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/1027 дугаартай захирамжаар ажил нь бүрэн хийгдээгүй болон Улсын комисс хүлээж аваагүй, он дамжин хийгдэхээр гэрээ байгуулагдсан нийт 6 төсөл, арга хэмжээний 792.6 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажил – 444.9 сая,
- Улаангом сумын гэр хороололд дэд бүтцийн шугамын нэмэлт ажил – 42.7 сая,
- 50 ортой хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж – 100.0 сая,
- Давст сумын халуун усны барилга – 45.0 сая,
- Завхан суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил – 80.0 сая,
- Завхан сумын төвийн тохижилтын ажил – 80.0 сая,

Харин орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдсан “Улаангом сумын 8-р багт голын голдирол өөрчлөн суваг татах” ажлыг Улаангом сумын ЗДТГ-т эрх шилжүүлснийг 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдөр “Эм Жи Би Эйч” ХХК-иар 2020 оны 05 дугаар сарын 19-ээс 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгүүлэхээр 2020/25 дугаартай гэрээ байгуулсан боловч гүйцэтгээгүй байхад санхүүжилт 4.0 сая төгрөгийг аймгийн Барилгын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Иймд хийгдэх боломжгүй болсон “Улаангом сумын 8-р багт голын голдирол өөрчлөн суваг татах” ажлын санхүүжилт 4.0 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэхийг зөвлөмж болгов.

2.2.2. Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлагыг хангаж байна.

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалт, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 7 төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 249.0 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.

Хүснэгт № 5 ТАХ-ний хүрээнд нийлүүлэгдсэн машин, тоног төхөөрөмж /мянган төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		2020 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах	
1	50 ортой хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж	2020	2020	100,000.0
2	Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэлтийн тасгийн тоног төхөөрөмж	2020	2020	50,000.0
3	Зүүнговь сумын сургуулийн сургалтын тоног төхөөрөмж	2020	2020	4,000.0
4	Аймгийн аудитын газарт автомашин	2020	2020	20,000.0
5	Хилийн зарим заставуудад нарны самбар, хөлдөөгч нийлүүлэх	2020	2020	25,000.0
6	Цагдаагийн газарт камерын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж	2020	2020	25,000.0
7	Мэргэжлийн хяналтын газарт автомашины дэмжлэг	2020	2020	15,000.0
	Дүн			249,000.0

/Эх сурвалж: Орон нутгийн 2020 оны хөрөнгө оруулалтын жагсаалт/

Дээрх машин, тоног төхөөрөмжүүд техникийн тодорхойлолт болон холбогдох баримт бичигт тусгагдсан шаардлагыг хангаж байна.

2.2.3. Хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон гэр хорооллын дэд бүтцийн шугамыг тухайн ашиглагч байгууллагын хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэг, Цагдаагийн газар, Хилийн 0311 дугаар анги, Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургуульд техник, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Увс аймаг дахь Төрийн аудитын газар болон Мэргэжлийн хяналтын газарт авто тээврийн хэрэгсэл нийлүүлэгдсэнийг хүлээн авч бүртгэлд тусгасан бөгөөд ашиглалт хэвийн байна.

Түүнчлэн Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 16.3 дахь хэсэгт “Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана” гэж заасны дагуу Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлыг аймгийн Засаг даргын тамгын газрын эргэлтийн хөрөнгийн хэсэгт бүртгэлтэй байгаа хэдий ч ажил нь дуусаж, улсын комисс хүлээн авсан 1, 2, 3, 4, 5, 6, 9, 10, 11, 12-р багцын ажлуудын өмчлөлийн асуудал шийдвэрлэгдээгүй байна.

Цаашид гэр хорооллын дэд бүтцийн шугамын бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу шийдвэрлүүлэхийг зөвлөлөө.

2.3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

2.3.1. Гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажил захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.12 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно” гэж заажээ.

2020 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн Улаангом сумын 4, 5, 6, 7, 11-р багийн гэр хороололд дэд бүтцийн шугамын ажил, Улаангом сумын гэр хороололд бохирын шугам, Улаангом сумын гэр хороололд дэд бүтцийн шугамын нэмэлт, Давст сумын халуун усны барилга, Улаангом сумын 2-р багт тоглоомын талбай барих, Улаангом сум доторх авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, зогсоол, засвар арчлалт, Улаангом-Улаан уул чиглэлд дугуйн зам, явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг хийх авто замыг сайжруулах ажлуудад аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Уг хяналтын хүрээнд Улаангом сумын гэр хорооллын дэд бүтцийн шугамын зарим материалын марк зөрсөн зөрчил илэрснийг Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.5 дахь заалтад “барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах” гэж заасны дагуу лабораторийн шинжилгээгээр техникийн үзүүлэлтийг тодорхойлуулж, дүгнэлт гаргуулсан байна.

Түүнчлэн хяналтын явцад Улаангом сумын гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажлын 7 дугаар багцын хүрээнд хийгдсэн сувгийн цутгалд стандартад хүрээгүй, Улаангом сум доторх авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, зогсоол, засвар арчлалт ажлын хүрээнд хийгдсэн 2 хурд сааруулагч стандартын шаардлага хангаагүй зөрчлүүдийг илрүүлсэн байна.

Мөн Улаангом сумын гэр хороололд дэд бүтцийн шугамын ажлын 1, 2, 3, 4, 5, 6, 9, 10, 11, 12-р багцын хүрээнд хийгдсэн ажлуудыг дараах нийтлэг үүрэг даалгавартайгаар хүлээн авсан байна. Үүнд:

- Худгийн шат болон металл хийц будах, силфон компесаторт чиглүүлэгч бэхэлгээ хийх, яндан хоолой дулаалах, богино холбоос тасалж битүүлэх, авто замыг зориулалтын асбалт бетон тавьж нөхөх,
- Дулааны худаг дотор байгаа цахилгааны утсыг гаргах, явган хүний замын алаг хавтанг нөхөн сэргээх,
- УДДТ12-ын шугамын хоёр худаг дотор ус юүлэгч хийх, нөхөн сэргээх ажлыг гүйцээж хийх, холбооны худаг цэвэрлэх, зарим худгийн битүүмжлэлийг сайжруулах, тоолуур шинэчлэх гэх мэт.

Дээрх үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж ажиллахыг зөвлөлөө.

Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.4 дэх хэсэгт “зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх”, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.1.4 дэх хэсэгт “Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээг байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах” гэж заасны дагуу аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Улаангом сумын гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажлын зураг төсөв хийсэн “Урбан девелопмент консалтинг групп” ХХК-тай 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр гэрээ байгуулжээ. Уг гэрээний дагуу барилга угсралтын ажлын явцад 4 удаа зохиогчийн хяналтыг хийсэн байна. Хяналтаар сувгийн ханын ус тусгаарлалтыг дутуу гүйцэтгэсэн, хоолойн тулгууруудын алгаслал, шугам хоолойн зэв бохирдлыг цэвэрлэж паскдаагүй, сувгийн хучилтыг элс, цементэн зуурмагаар чигжээгүй зэрэг зөрчил илрүүлж тухай бүрд нь засах зөвлөмжийг албан бичгээр өгч ажилласан байна.

2.3.2. Захиалагч болон зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр арилгуулж ажилласан байна.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.11 дэх хэсэгт “Захиалагч барилга байгууламжийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хийх үзлэг, шалгалтын ажилд оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй” гэж заасны дагуу аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн тухай бүр үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулж ажилласан байна.

Түүнчлэн гэр хорооллын дэд бүтцийн шугамын ажлын барилга угсралтын явцад “Урбан девелопмент консалтинг групп” ХХК зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэн тухай бүр үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулж ажилласан байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- 1.Барилга байгууламжийн зураг, төсвийг захиалагчийн тавьсан шаардлагын дагуу боловсруулсан байна.
- 2.Аймгийн ИТХ-аар Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Замын сан, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр нийт 34 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 26 төсөл, арга хэмжээг бүрэн, 7 төсөл, арга хэмжээг дутуу хэрэгжүүлж, 1 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.
- 3.Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд томилогдсон гишүүдийн 14.5-28.5 хувь нь худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх гэсэн шаардлагыг хангаагүй байна.
- 4.Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлагыг хангаж байна.
- 5.Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛС
УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас: 7045-2315, Факс: 7045-4095

Цахим шуудан: info@uvs.gov.mn

Цахим хуудас: www.uvs.gov.mn

2021.07.05 № 1/1031


танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА



Ч.ЧИМЭД

D disk: AZDTG- zasag A-5

8521020658



УВС АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас/Факс: 7045-3232

2021.07.05 № 99

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Хариу тайлбар хүргүүлэх тухай

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 11/05 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 3.7-д Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилга, байгууламжийг барьж дуусах хүртэл захиалагч байгууллагын эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэн санхүүгийн тайланд тусгана гэж заасны дагуу гэр хорооллын дэд бүтцийн шугам сүлжээн нь аймгийн ЗДТГ-ын эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй болно.

Гэр хорооллын дэд бүтцийн дулааны шугам сүлжээний ашиглагч байгууллага нь "Дулааны 2-р станц" төрийн өмчит компани тул аймгийн ИТХ-ын шийдвэрээр орон нутгийн өмчөөс төрийн өмчит шилжүүлэх саналыг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлснээр ашиглагч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ.

Иймд дээрх дэд бүтцийн шугам сүлжээ нь захиалагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй бөгөөд аймгийн ИТХ-аас төрийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлэхээр шийдвэрлэснээр ашиглагч байгууллагын дансанд бүртгэнэ.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ё.МӨНХЗУЛ

D/Албан бичиг/ A4.docx

8521070078



УВС АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Улаангом, Увс аймаг, 85160
Утас: 7045-4830, Факс: 7045-3122
Цахим шуудан: uvs@gazar.gov.mn
Цахим хуудас: www.uvs.gazar.gov.mn

2021.07.02 № 402
танай _____ -ны № _____ -т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2020 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажилд хийсэн аудитын тайлантай танилцав.

Тухайн тайланд манай байгууллагатай холбоотой дурдсан ажлуудад нэмж, хасах саналгүй байна.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ОТГОНБОЛД



8521040645

Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн саналд дараах хариуг хүргүүлж байна.

1. Аймгийн Засаг даргад хүргүүлсэн тайлангийн төсөлд Засаг даргын ирүүлсэн 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 1/1031 дугаар бичигт “аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа, зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллах болно” гэсэн байх тул саналд тайлбар өгөх шаардлагагүй гэж үзлээ.

2. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ирүүлсэн 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 402 дугаар бичигт “тухайн тайланд манай байгууллагатай холбоотой дурдсан ажлуудад нэмж, хасах саналгүй байна” гэсэн байх тул саналд тайлбар өгөх шаардлагагүй гэж үзлээ.

3. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ирүүлсэн 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 99 дугаар бичгээр ирүүлсэн саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт орууллаа.

Зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч
хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Ч.Чимэд танаа

1. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний
хороонд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн гишүүн томилж
байх.
2. Гэрээний хугацаанд хийж дуусаагүй төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч
компаниар хийж гүйцэтгүүлэх.

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Б.Эрдэнэсүрэн танаа

1. Хийгдэх боломжгүй болсон "Улаангом сумын 8-р багт голын голдирол
өөрчлөн суваг татах" ажлын санхүүжилт 4.0 сая төгрөгийг аймгийн Орон
нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

М.БАТСУУРЬ

М.БАТ-АМГАЛАН

С.БАТСАЙХАН

Т.ЗОЛОО

Ч.МӨНХТОГТОХ